



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 10 сарын 30 өдөр

Дугаар А/736

Булган сум

**Газар өмчлөх эрх хүчингүй
болгох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.3, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар өмчилсөн иргэн Дорж овогтой Алтанжолоо (ГЮ67111061) Булган сум 2 дугаар баг Хөх чулуут 12 дугаар гудамж 1216 тоотод байршилтай 6308000196 нэгж талбарын дугаартай 730 м2 газрыг өөр иргэнд давхардуулан захирамжилсан тул аймгийн Засаг даргын 2005 оны 102 дугаар захирамжийн Д.Алтанжолоотой холбогдох хэсгийг хүчингүй болгосугай.

2.Дээрх зөрчлийг арилгаж, Газар өмчлөлийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулахыг Булган сумын Засаг дарга (П.Нөхөрлөлбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

